



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор  
2023 оны 02 дугаар сарын 17

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер: А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)  
Аудитор: Н.Батчимэг  
Утас: 91113253 Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement, bayankhongor@audit.gov.mn

*Со.С.О.О.О.О.* № *2/110*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 үндсэн зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Боловсрол шинжлэх ухааны газраас 93.3 хувиар үнэлсэн байна.

005020433

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the State Audit Agency and the name of the official, B. Mönkhbat. The signature is written in a cursive style.

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>80,668,394.20</u></b>	<b><u>217,258,923.36</u></b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	137,269,779.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	137,269,779.16
3121	Төгрөг	00.00	137,269,779.16
31211	Төрийн сангийн харилцах	00.00	137,269,779.16
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>80,668,394.20</b>	<b>79,989,144.20</b>
351	Түүхий эд материал	34,616,686.00	32,090,686.00
35110	Тусгай зориулалттай материал	27,857,686.00	27,857,686.00
35130	Эм боох материал	6,759,000.00	4,233,000.00
354	Хангамжийн материал	46,051,708.20	47,898,458.20
35410	Бичиг хэргийн материал	100,000.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	17,605,607.80	16,074,857.80
35440	Түлш, шатах тослох материал	00.40	00.40
35470	Бусад хангамжийн материал	28,346,100.00	31,723,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,553,375,363.47</u></b>	<b><u>1,493,748,897.63</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,553,375,363.47	1,493,748,897.63
392	Биет хөрөнгө	1,523,077,363.47	1,463,450,897.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,547,931,617.44	1,547,931,617.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-186,208,925.71	-247,125,704.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,006,269.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,006,269.00	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,687,454.86	275,184,254.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-132,670,192.24	-159,394,050.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,408,976.00	98,408,976.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-56,506,160.88	-66,988,789.16
39217	Ном	15,434,594.00	15,434,594.00
393	Биет бус хөрөнгө	30,298,000.00	30,298,000.00
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,298,000.00	30,298,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,634,043,757.67</u></b>	<b><u>1,711,007,820.99</u></b>
413	Өглөг	34,700.00	4,131,578.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,096,878.54
4136	Бусад өглөг	34,700.00	34,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	34,700.00	34,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,634,009,057.67</u></b>	<b><u>1,706,876,242.45</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,634,009,057.67	1,706,876,242.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	770,683,652.01	770,683,652.01
51101	Өмч: - төрийн	770,683,652.01	770,683,652.01

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-38,775,962.53</b>	<b>34,091,222.25</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-38,775,962.53	-38,775,962.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	72,867,184.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	902,101,368.19	902,101,368.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,634,043,757.67</u></b>	<b><u>1,711,007,820.99</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>805,902,510.00</b>	<b>1,074,198,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,433,000.00</b>	<b>26,543,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>46,433,000.00</b>	<b>26,543,500.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,531,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,531,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,469,510.00</b>	<b>1,047,654,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>646,962,500.00</b>	<b>917,656,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	917,656,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	646,962,500.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>19,999,939.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,999,939.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>92,507,071.00</b>	<b>129,998,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,507,071.00	129,998,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>824,662,534.97</b>	<b>1,001,330,815.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>824,662,534.97</b>	<b>1,001,330,815.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>785,641,169.59</b>	<b>954,264,513.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>490,411,514.54</b>	<b>592,439,552.27</b>
210101	Үндсэн цалин	359,510,140.51	417,869,754.73
210102	Нэмэгдэл	93,990,470.39	134,150,541.14
210104	Урамшуулал	36,910,903.64	16,388,391.85
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	24,030,864.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>63,818,259.08</b>	<b>70,842,314.14</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,624,857.42	47,980,839.22
210202	Тэтгэмжийн даатгал	5,383,261.42	5,789,018.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,949,370.74	4,651,214.65
210204	Ажилгүйдлийн даатгал	987,342.68	1,124,455.59
210205	Эрүүл мэндийн даатгал	9,873,426.82	11,296,786.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,513,811.00</b>	<b>100,210,409.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,343,211.00	5,209,775.00
210302	Түлш, халаалт	87,757,900.00	94,261,999.00
210303	Цэвэр, бохир ус	412,700.00	738,635.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,395,410.00</b>	<b>7,812,750.00</b>
210401	Бичиг хэрэг	1,193,000.00	273,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,299,410.00	3,680,700.00

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,163,900.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	269,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,289,400.00	3,498,650.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,834,000.00</b>	<b>58,156,825.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,140,050.00	2,659,400.00
210502	Хоол, хүнс	19,126,950.00	54,132,425.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,567,000.00	1,365,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,426,560.00</b>	<b>1,626,650.00</b>
210604	Урсгал засвар	3,426,560.00	1,626,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>344,000.00</b>	<b>351,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	344,000.00	351,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,447,900.00</b>	<b>5,175,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,707,900.00	1,531,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	3,644,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>98,449,714.97</b>	<b>117,649,312.84</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,945,500.00	9,669,755.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,791,540.00	9,856,292.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,712,674.97	98,123,265.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,021,365.38</b>	<b>47,066,301.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,537,970.00</b>	<b>45,418,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,166,700.00	45,418,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,750,070.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	621,200.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>69.00</b>	<b>00.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,483,326.38</b>	<b>1,648,001.97</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,483,326.38	1,648,001.97
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-18,760,024.97</b>	<b>72,867,184.78</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>759,469,510.00</b>	<b>1,049,186,200.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,531,700.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>1,531,700.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,531,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,531,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,469,510.00</b>	<b>1,047,654,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>646,962,500.00</b>	<b>917,656,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	917,656,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	646,962,500.00	00.00

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,999,939.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,999,939.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,507,071.00	129,998,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,507,071.00	129,998,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>736,506,510.00</b>	<b>898,431,420.84</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	736,506,510.00	898,431,420.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	697,485,144.62	841,148,618.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,507,764.06	588,395,921.09
210101	Үндсэн цалин	361,786,226.84	413,826,123.55
210102	Нэмэгдэл	91,128,360.87	134,150,541.14
210104	Урамшуулал	36,094,076.35	16,388,391.85
210105	Гэрээт ажлын хөлс	499,100.00	24,030,864.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,221,109.56	70,789,066.78
210201	Тэтгэврийн даатгал	46,888,599.12	48,034,006.70
210202	Тэтгэмжийн даатгал	4,613,210.44	5,762,414.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,661,700.00	4,629,931.66
210204	Ажилгүйдлийн даатгал	902,300.00	1,119,134.96
210205	Эрүүл мэндийн даатгал	9,155,300.00	11,243,578.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,513,811.00	100,637,499.00
210301	Гэрэл, цахилгаан	3,343,211.00	4,875,500.00
210302	Түлш, халаалт	87,757,900.00	94,261,999.00
210303	Цэвэр, бохир ус	412,700.00	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,105,610.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,193,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,299,410.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,138,900.00	00.00
210404	Ном, хэвлэл	294,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,180,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,600.00	00.00
2105	Нормативт зардал	21,723,650.00	43,915,925.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	275,400.00	00.00
210502	Хоол, хүнс	19,209,250.00	43,915,925.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,239,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,479,760.00	862,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,240,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,239,760.00	862,100.00
2107	Томилолт, зочны зардал	344,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	344,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,447,900.00	8,427,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,707,900.00	1,531,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	6,896,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,141,540.00</b>	<b>28,120,407.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,350,000.00	17,796,645.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,791,540.00	10,323,762.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,021,365.38</b>	<b>57,282,801.97</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,537,970.00</b>	<b>55,634,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,166,700.00	55,634,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,750,070.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	621,200.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>69.00</b>	<b>00.00</b>
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,483,326.38</b>	<b>1,648,001.97</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,483,326.38	1,648,001.97
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>22,963,000.00</u></b>	<b><u>150,754,779.16</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>22,963,000.00</b>	<b>13,485,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,963,000.00</b>	<b>13,485,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>22,963,000.00</b>	<b>13,485,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,963,000.00	13,485,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-22,963,000.00</u></b>	<b><u>-13,485,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>137,269,779.16</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>137,269,779.16</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	902,514,882.82	-3,801,892.55	00.00	1,669,396,642.28
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	770,683,652.01	902,514,882.82	-3,801,892.55	00.00	1,669,396,642.28
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,133,565.79	00.00	-25,133,565.79
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	902,101,368.19	-38,775,962.53	00.00	1,634,009,057.67
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	902,101,368.19	-38,775,962.53	00.00	1,634,009,057.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	770,683,652.01	902,101,368.19	-38,775,962.53	00.00	1,634,009,057.67
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	72,867,184.78	00.00	72,867,184.78
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	902,101,368.19	34,091,222.25	00.00	1,706,876,242.45

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,049,186,200.00	910,268,418.87	138,917,781.13	86.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,049,186,200.00	910,268,418.87	138,917,781.13	86.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	989,111,700.00	854,633,618.87	134,478,081.13	86.4
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	700,880,700.00	588,395,921.09	112,484,778.91	84.0
210101	Үндсэн цалин	506,662,000.00	413,826,123.55	92,835,876.45	81.7
210102	Нэмэгдэл	154,999,100.00	134,150,541.14	20,848,558.86	86.5
210104	Урамшуулал	14,010,300.00	16,388,391.85	-2,378,091.85	117.0
210105	Гэрээт ажлын хөлс	25,209,300.00	24,030,864.55	1,178,435.45	95.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	87,610,100.00	70,789,066.78	16,821,033.22	80.8
210201	Тэтгэврийн даатгал	59,574,900.00	48,034,006.70	11,540,893.30	80.6
210202	Тэтгэмжийн даатгал	7,008,800.00	5,762,414.84	1,246,385.16	82.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,607,100.00	4,629,931.66	977,168.34	82.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,401,800.00	1,119,134.96	282,665.04	79.8
210205	Эрүүл мэндийн даатгал	14,017,500.00	11,243,578.62	2,773,921.38	80.2
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	100,637,499.00	-100,637,499.00	
210302	Түлш, халаалт	94,262,000.00	94,261,999.00	1.00	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	43,916,400.00	43,915,925.00	475.00	100.0
210502	Хоол, хүнс	43,916,400.00	43,915,925.00	475.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	862,100.00	-862,100.00	
210604	Урсгал засвар	1,000,000.00	862,100.00	137,900.00	86.2
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,549,900.00	8,427,700.00	122,200.00	98.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,018,200.00	6,896,000.00	122,200.00	98.3
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46517100.00	41605407.00	4,911,693.00	89.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,989,800.00	31,281,645.00	4,708,155.00	86.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,527,300.00	10,323,762.00	203,538.00	98.1
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	60074500.00	55634800.00	4,439,700.00	92.6
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	60,074,500.00	55,634,800.00	4,439,700.00	92.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	60,074,500.00	55,634,800.00	4,439,700.00	92.6
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	919,188,200.00	1,049,186,200.00	-129,998,000.00	114.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	137,269,779.16	-137,269,779.16	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор сумын Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хуулийн дагуу нийгмийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 42 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, нийт 17 бүлэг, 445 сурагчтайгаас бага ангид 259, дунд ангид 171, дүйцүүлэх хөтөлбөрт 15 сурагч суралцаж, дотуур байранд 79 хүүхэд, үдийн цай хөтөлбөрт 259 хүүхэд хамрагдсан бөгөөд 2022 оны үйл ажиллагааны зардалд улсын төсвийн санхүүжилтээр 919,188.2 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 129.998.0 мянган төгрөг, нийт 1,049,186.2 мянган төгрөг батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургууль нь "сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй материаллаг болон нийгэм сэтгэлзүйн тавтай орчин бүрдүүлж ханган ажиллах" эрхэм зорилготой, "сургалтын чанарыг ахиулах, багш нарын арга зүй, ур чадварт ахиц гаргах" зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Захирал Ш.Даваацэрэн (2022.01.01-2022.08.25), Г.Долгор (2022.08.26-2022.12.31), 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Гантулга нар зурж, нярваар Ц.Ариунаа, Б.Эрдэнэ-Очир нар ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дүгээр тогтоолоор цалингийн шатлал,
- БШУС-ын 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/122 тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ЕБС-ийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУС-ын 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгалт хийсэн харин санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх НББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,711,007.8 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 76,964.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	137,269.8	137,269.8
Авлага	-	-	-
Бараа материал	80,668.4	79,989.1	(679.3)
Үндсэн хөрөнгө	1,939,066.9	1,967,557.4	28,490.5
Хуримтлагдсан элэгдэл	(385,691.5)	(473,808.5)	(88,117.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,634,043.8</b>	<b>1,711,007.8</b>	<b>76,964.0</b>
Өр төлбөр	34.7	4,410.9	4,376.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,634,009.1	1,706,596.9	72,587.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,634,043.8</b>	<b>1,711,007.8</b>	<b>76,964.0</b>

Дээрх хүснэгтээс харахад, Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 137,269.8 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 79,989.1 мянган төгрөг болж өмнөх оноос 679.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 124,964.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаандаа 125,643.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,939,066.9 мянган төгрөг болж 28,490.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13,485.0 мянга, БШУГ-аас 25,011.8 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлэн авч, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 10/46 тоот тогтоолоор 10,006.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Тайлант оны бараа материалын 34.7 мянган төгрөгийн өр төлбөртэй байсныг барагдуулаагүй, тайлант оны эцэст НДШ-ийн 53.2 мянган төгрөг, ҮЭ-ийн 291.6 мянган төгрөг, ХХОАТ-ын 3,752.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсэж тайлант оны эцэст 4,131.6 мянган төгрөгийн өртэй гарчээ. Энэ нь нягтлан бодогч ажиллагсдын цалингаас суутгасан тооцоог тухай бүр нь шилжүүлээгүй, тооцоог нийлээгүйгээс өглөгтэй гарсан, түүнд төсвийн менежер хяналт тавьж ажиллаагүй хариуцлагагүй хандсанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 72,587.8 мянган төгрөгөөр өсөж 1,706,596.9 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 814,513.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 129,998.0 мянган төгрөг, нийт зарлагыг 944,511.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд 2 удаа тодотгол хийж 104,674.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 917,656.5 мянган төгрөг, сурах бичгийн орлогоос 1,531.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 129,998.0 мянган төгрөг, нийт 1,049,186.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 917,656.5 мянган төгрөг, сурах бичгийн орлогоос 1,531.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 129,998.0 мянган төгрөг, нийт 31,049,186.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 917,656.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, сурах бичгийн орлогоос 1,531.7 мянган төгрөг төвлөрч 137,269.8 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг дансанд мөнгөн хөрөнгөөр үлдээсэн байна.

Орон нутгийн төсвөөс 129,998.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 128,350.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийж 1,648.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 910,268.4 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 98,331.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсөв</b>					
1	71802 Ерөнхий боловсрол	919,188.2	781,918.4	137,269.8	85.0%
1.1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,807.3	2,807.3	0.00	100.0%
1.2	80312 Сургалт семинар	1,403.6	1,391.5	12.1	99.1%
1.3	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,228.4	2,197.5	1,030.9	68.1%
1.4	81801 Үдийн цай хөтөлбөр	60,074.5	55,634.8	4,439.7	92.6%
1.5	81806 Дотуур байр	61,121.5	48,633.9	12,487.5	79.6%
1.6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,485.0	13,485.0	3,000.0	81.8%
1.7	81823 Боловсролын байгууллагын багш	6,316.4	6,131.7	184.7	97.0%
1.8	81834 Боловсролын стандарт	697,334.0	593,416.2	103,917.8	85.0%
1.9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	68,885.8	56,688.7	12,197.1	82.3%
1.10	81848 Түрээсийн сурах бичиг	1,531.7	1,531.7	0.00	100%
<b>Орон нутгийн төсөв</b>					
2	71802 Ерөнхий боловсрол	129,998.0	128,350.0	1,648.0	98.7%
2.1	80112 Нийтлэг үйлчилгээ	129,998.0	128,350.0	1,648.0	98.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЕБС нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 824,662.5 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 824,662.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,369.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,658.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдээгүй, харин халаалтын зардлыг өмнөх оноос 6,504.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2020-2021 оны хичээлийн жилд цар тахалтай холбоотойгоор үнэ нэмэгдээгүй, төсөвтөө багтаан төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 34 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 84 мэдээллийг байршуулаагүй, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд дулаанаар хангах, үдийн цай, хүнсний материал худалдан авах, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бий болгох 4 гэрээний 214,737.9 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 417,719.8 мянган төгрөгийн 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 127,043.0 мянган төгрөгийн 13 гүйлгээ, хүний нөөц, өмч хөрөнгө,

санхүүтэй холбоотой 12 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 83,271.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 60,852.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг дутуу мэдээлсэн байна. Мөн гэрэл цахилгаан, цэвэр бохир ус нийлүүлэх гэрээнүүдийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 470.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан, 7,487.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 54 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	470.1	1	470.1	100
Зөвлөмж	4	7,487.0	4	7,487.0	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>7,957.1</b>	<b>5</b>	<b>7,957.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т "Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байх"-ыг БСШУСС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба 2022 оны 1, 2 дугаар саруудад бүрэн ажиллаагүй, хоолны ирцэд хяналт тавьснаар үдийн цай хөтөлбөрийн зардал 4,439.7 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 279.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын хэлтэст төлөх өр төлбөрийг 279.4 мянган төгрөгөөр илүү тусгасныг санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар нийт 9,438.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,686.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 3,281.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,469.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Сургуулийн захирлын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Зардал зарцуулах тухай" А/35 дугаар тушаалаар намрын спартикадын шагналд өгөх өргөмжлөл, үнэ бүхий зүйлсийн зардалд 1,391.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант хугацаанд зориулалт бусаар өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан 1,391.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Нийгмийн ажилтан Э.Хатанбаатарт Өвөрхангай аймагт сургалтад хамрагдахад замын зардлын баримтгүй байхад замын зардалд 135.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээнд зарцуулсан 135.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3. Цахим хэрэглээний зардлаас Захирал Г.Долгор, Нийгмийн ажилтан Э.Хатанбаатар нарт 11 дүгээр сард тус бүр 30.0 мянга, 12 дугаар сард 50.0 мянга, нийт 160.0 мянган төгрөгийг датаны зардалд шилжүүлсэн байна

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ын 1.4 дэх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 160.0 мянган төгрөгийг холбогдох буруутай алтан тушаалтнуудаар төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1. Ажиллагсдын 2022 оны 5-11 дүгээр сарын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 3,281.8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх “ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2022 оны 3,281.8 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 83,271.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 60,852.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг дутуу мэдээлсэн байна. Мөн гэрэл цахилгаан, цэвэр бохир ус нийлүүлэх гэрээнүүдийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх албан шаардлагыг өгөв.

## **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### ***Өр төлбөрийн холбоотой асуудал***

5.3.1. Тайлант онд өмнөх оны 34.7 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, цалин хөлстэй холбоотой НДШ-ийн 53.2 мянга, ҮЭ-ийн 291.6 мянга, ХХОАТ-ын 3,752.0 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж нийт 4,131.5 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж,

цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”. гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн, цаашид төсвийн шууд захирагч нь төсвийг үр ашигтай удирдаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

#### ***Зардлын холбоотой асуудал.***

5.3.2. Хичээл практикийн зардлаас 2022 оны 5 дугаар сард шатахууны зардалд 194.2 мянга, 11 дүгээр сард хулдаасан хэвлэлд 144.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн ангилал ашиглах заавар”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 190, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалуудыг хэрэгжүүлж, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 34 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 84 мэдээллийг байршуулаагүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 83,271.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 60,852.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг дутуу мэдээлсэн, нийт 144123.7 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна. Мөн гэрэл цахилгаан, цэвэр бохир ус нийлүүлэх гэрээнүүдийг байршуулаагүй байна.	1	0	0	0	1	0	0	0	0
Дүн	1	0	0	0	1	0	0	0	0

00000